

2026 оны 09 сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдсан газар огноо: Тавилга ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2026 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-уул дүүргийн, 20-р хороо Чингисийн өргөн чөлөө-81 Ибис Стайлс Улаанбаатар зочид буудал /Мишээл экспогийн чанх хойно, Polaris их дэлгүүр/-ийн 4 давхарын танхимд эхэллээ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурлын дарга О.Батнаран нээв.

Хурлын дарга О.Батнаран /цаашид “Хурлын дарга” гэх/ **үг хэлэв:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие О.Батнаран “Тавилга” ХК-ийн хамгийн их хувьцааг эзэмшигч болсон. Тийм учир хурлынхаа үйл ажиллагааг эхлүүлж Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгоё. Тооллогын комиссын дарга ирцээ танилцуулья.

Тооллогын комиссын дарга Б.Батцэнгэл: Сайн байцгаана уу? “Тавилга” ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дарга Б.Батцэнгэл байна. Тооллогын комиссын ирцийн дүнг танилцуулья.

1. “Тавилга” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал нийт саналын эрх бүхий хувьцааны 94,35%-д хүрснийг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т заагдсаны дагуу хувьцааны 94,35%-ийн хувьцаа эзэмшигчид оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Хурлын дарга: Хэлэлцэх асуудалтай холбоотой ХЭ-ээс асуух асуулт, санал байгаа бол хэлнэ үү.

Хурлын дарга: Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн танилцуулгыг та бүхэнд хүргэж байна. Хуралд оролцогчдоос санал гарсангүй. Байхгүй бол ингээд хэлэлцэх асуудлаа батлах уу? (хуралд оролцогчид бүгд зөвшөөрөв)

Хурлын дарга: Өөр санал байхгүй бол саналаа хураая. Хэлэлцэж байгаа асуудал болгоноор кумулятив аргаар саналын тоогоо саналын хуудсанд бичиж саналаа өгнө. *(Тооллогын комисс саналыг нэгтгэх хооронд 10 минут хурал түр завсарлаад үргэлжлэв.)*

Хурлын дарга: Тооллогын комисс дүнгээ танилцуулаарай.

Хурлын дарга: Тооллогын комиссын дүнг үндэслэн, Тавилга ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдэд О.Батнаран, Б.Оюун-Эрдэнэ, Б.Сарнай, Б.Саруул, О.Нарангэрэл, С.Бумбабаяр, хараат бус гишүүдэд Х.Эрдэнэбулган, Л.Амгалан, А.Мөнхбаяр нар сонгогдлоо.

Хурлын дарга: Тус хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурлын дарга хурлыг хаая. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Нарийн бичгийн дарга:

Б.Сарнаа

Х.Баяржаргал

Хурлын дарга:



О.Батнаран